



“МОНГОЛ СУДЛАЛЫН ШИНЭ ЭРИН” - VI ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ



Танилцуулга:

Хүндэт эрдэмтэн, судлаачид аа! Та бүхнийг олон улсын эрдэм шинжилгээний “Монгол судлалын шинэ эрин” - VI хуралд оролцохыг урьж байна.

Энэхүү хурал нь МУБИС-ийн Монгол судлалын сургууль байгуулагдсан цагаас эхлэн жил бүр амжилттай зохион байгуулагдаж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд олон улсын хэмжээнд өргөжин ОХУ, БНХАУ, Япон, Солонгос, Англи, Канад, Энэтхэг зэрэг гадаад орны эрдэмтэд идэвхтэй оролцон, илтгэлээ хэлэлцүүлж ирлээ. 2011 оноос хойш энэ хурлыг “Монгол судлалын шинэ эрин” гэх нэртэй хийж эхлээд өдгөө VI хурлыг бид зохион байгуулах гэж байна.

Хурлын зорилго нь:

МУБИС-ийн НХУС-ийн МСХ-гээс Монгол хэл судлал, Монголын утга зохиол, Сэтгүүл зүй – олон нийтийн харилцаа, Монголын түүх угсаатны зүй, археологи, Нийгэм, соёл судлаач эрдэмтдийн дунд Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, Монгол судлалын ойр үеийн шинэ судалгааны ололт амжилтаа хэлэлцүүлэх, судалгааны үнэ цэнтэй мэдээлэл солилцоход чиглэнэ.

Хурал болох хугацаа:

2026 оны 4-р сарын 16-17-нд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод, МУБИС-д зохион байгуулагдана.

- Оролцогчийн мэдүүлэг ирүүлэх хугацаа -2025.01.30-ны дотор.
- Илтгэлийн хураангуй ирүүлэх хугацаа - 2025.02.30-ны дотор.
- Илтгэлийг цахимаар ирүүлэх хугацаа – 2025.03.20-ны дотор.

Хурал болох газар, хаяг:

Улаанбаатар хот, СБД, VIII хороо, Бага тойруу-14, Улаанбаатар-48, Монгол Улс-14191

Хурлын хэл: Монгол хэл, англи хэл

Хуралд оролцох хэлбэр: Танхим, онлайн

Хамрах судалгааны салбар, чиглэл:

I. “Монгол хэл шинжлэлийн хөгжлийн чиг хандлага” салбар хуралдаанд:

- Монгол хэл судлал
- Монгол бичиг, сурвалж судлал
- Харьцуулсан болон зэрэгцүүлсэн хэл шинжлэл

II. “Монголын утга зохиол судлалын шинэ чиг хандлага” салбар хуралдаанд:

- Монгол аман зохиол, ардын аман билиг
- Монголын эртний уран зохиол
- Монголын орчин үеийн уран зохиол
- Харьцуулсан уран зохиол

III. “Цахим шилжилт, мэдээлэл харилцаа” салбар хуралдаанд:

- Сэтгүүл зүйн түүх судлал

- Онол практикийн судалгаа
- Олон нийтийн харилцаа, PR
- Мэдээллийн шинэ хэрэгсэл

IV. “Их Монгол улсын үеийн археологи, түүх, соёлын судалгаа” салбар хуралдаанд:

- Монголын түүх
- Угсаатны судлал
- Эртний судлал

V. “Монголын улс төр, нийгэм, соёлын шинэчлэл” салбар хуралдаанд:

- Эрх зүй
- Улс төр
- Социологи
- Монголын философи

Хурлын мэдүүлгийг хугацаандаа багтааж ирүүлэхийг хүсэж байна. Салбар хурлын илтгэлд тодорхой тоо тавьж буй тул чанарын шаардлага хангасан илтгэгчид бид оролцохыг зөвшөөрсөн урилга хүргүүлэх болно. Хуралд ирж очих унааны болон визатай холбогдох зардал, байр хоолны зардлыг илтгэгч хариуцна.

DOI дугаар бүхий МУБИС-ийн *Mongolian Journal of Humanities and Social Sciences* сэтгүүл нь шаардлага хангасан илтгэлийг нийтлэх болно.

Холбогдох хаяг:

E-mail: ims.mnue@msue.edu.mn
Mongolsudlal2025@gmail.com

Mobile: +976 77775115
 + 976 9915-8411

ОРОЛЦОГЧИЙН МЭДҮҮЛЭГ

Илтгэгчийн овог, нэр	
Улс, хот	
Ажлын газар	
Холбогдох утас	
Цахим хаяг	
Албан ажил	
Эрдмийн зэрэг, цол	
Илтгэлийн нэр (монгол, англи)	
Илтгэлийн хураангуй (монгол, англи хэлээр, 450-500 үг)	
Түлхүүр үг	
Хуралд оролцох хэлбэр	

МОНГОЛ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН
 ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Илтгэлд тавигдах шаардлага:

Ерөнхий шаардлага:

Илтгэл нь хурлын чиглэл, салбарын хүрээнд байх.

Илтгэл өмнө нь хэвлэгдээгүй, өөр хуралд хэлэлцүүлж байгаагүй байх.

Судалгааны үр дүн шинэлэг, онол-арга зүйн үндэслэл сайтай байх.

Сэдэв буюу гарчиг:

Гарчиг нь илтгэлийн гол санааг агуулсан товч, тодорхой, оновчтой томъёологдсон 11-с дээшгүй үгэнд багтсан, Times New Roman, 11 pt, Bold, ТОМ ҮСГЭЭР, мөр голлон бичигдсэн байна. Өгүүллийн нэр, товчлолыг англи хэлээр хийсэн байх.

Зохиогчийн хаяг:

Ажил, албан тушаал, цол зэрэг, зохиогчийн овог нэр

Түлхүүр үг:

Илтгэлийн утгыг илэрхийлж чадахуйц 6-8 үг

Хураангуй:

Хураангуй нь илтгэлийн агуулгын гол утга санааг товч тодорхой, ойлгомжтой байдлаар илэрхийлсэн монгол, англи хэлээр 450-500 орчим үгээс бүрдэнэ. Хураангуйг Times New Roman дээр 11 pt үсгийн өндөртэйгөөр бичнэ.

Эшлэл хийх:

Бичвэр дотор эх сурвалжийн зохиогч болон хэвлэсэн он, хуудасны дугаарыг зааж өгнө.

Жишээ: (Галбаатар, 2012, х.210)

Ном зүй:

-Ном зүйн жагсаалт нь үндсэн бичвэртэй адил үсгийн фонт, хэмжээтэй байна.

-Мөр хоорондын зай 1.0

-Ном зүйг АРА загвар ашиглан бичнэ. Жишээ: Дулам, С., Хасбаатар, Ц., (1980). *Уран зохиолын онолын үүд*. Улаанбаатар: УХГ

Техник шаардлага:

- Илтгэл нь (А4) хэмжээтэй 4-5 хуудсанд багтсан байна.

-Илтгэлийг Microsoft office Word программыг ашиглан Times new roman фонт, 11 pt үсгийн өндрийг сонгон бичнэ.

- Илтгэлийг А4 цаасанд хуудасны дээд, доод талаас 3 см, баруун, зүүн талаас 2,5 см, мөр хоорондын зай 1.15 см байна.

-Хүснэгт, зураг, график доторх текстийн үсгийн өндөр Times New Roman фонт дээр 10 pt байна.

-Галиг үсэг болон бусад фонт хэрэглэсэн бол үсгийн фонтыг өгөх.

Та бүхэнд амжилт хүсье!